

ХУРЛЫН ЗАР №1

Эрхэм хүндэт нөхөд өө!

Та бүгдийг 2020 оны 8 дугаар сарын 12-16 өдрүүдийн хооронд «Дорж Банзаровын нэрэмжит Буриад Улсын Их Сургууль» (ОХУ-ын Улаан-Үүд хот)-д зохион байгуулагдах гэж буй IV дахь удаагийн монгол хэл, хэлшинжлэлийн олон улсын эрдэм шинжилгээний хуралд (ML 2020) оролцохыг урьж байна.

Эрдэм шинжилгээний хурлын сэдэв: «XXI зууны монгол хэл: Орчин үеийн хандлага ба судалгаа шинжилгээний хэтийн төлөв».

Зохион байгуулагч: Дорж Банзаровын нэрэмжит Буриад Улсын Их Сургууль (ОХУ-ын Улаан-Үүд хот), ОХУ-ын ШУА-ийн Хэлшинжлэлийн Хүрээлэн (ОХУ-ын Санкт-Петербург хот), Б.Б.Городовиковын нэрэмжит Халимагийн Их Сургууль (ОХУ-ын Элистэй хот), ОХУ-ын ШУА-ийн Халимагийн эрдэм шинжилгээний төв (ОХУ-ын Элистэй хот), Өвөр Монголын Их Сургууль (БНХАУ-ын Хөх Хот).

Тус зохион байгуулагдах гэж буй эрдэм шинжилгээний хурал нь урд өмнөх хурлуудаар (ОХУ-ын ШУА-ийн Хэлшинжлэлийн Хүрээлэн, Санкт-Петербург хот, 2013; Б.Б.Городовиковын нэрэмжит Халимагийн Их Сургууль, Элистэй хот, 2016; Өвөр Монголын Их Сургууль, БНХАУ-ын Чифэн хот, 2018) авч хэлэлцэж байсан асуудлуудын үргэлжлэл юм. Хурлын сэдвийн хүрээнд монгол хэлшинжлэлийн орчин цагийн судлалын асуудлыг өргөн хүрээнд авч хэлэлцэнэ. Үндсэн зорилго нь: монгол хэлний судалгаа шинжилгээ хийж буй эрдэмтэд хоорондоо санаа бодол хийгээд арга туршилгаа солилцох.

Энэхүү эрдэм шинжилгээний хуралд ОХУ болон бусад гадаад улсын эрдэмтэн судлаачид, их дээд сургуулиудын багш нар, эрдэм шинжилгээний байгууллагуудын ажилтнууд, түүнчлэн монгол хэл бичгийн чиглэлээр судалгаа шинжилгээ хийдэг аспирантууд уригдаж оролцоно.

Эрдэм шинжилгээний хурлын явцад дараах сэдвүүдийг хэлэлцэхээр төлөвлөж байна. Үүнд:

1. Монгол хэлийг судлах шинжлэх орчин үеийн арга барил ба зарчим
2. Орчин цагийн монгол хэл бичиг судлалын тулгамдсан асуудлууд
3. Монгол бүлгийн хэлний түүхэн харьцуулсан судлалын асуудлууд
4. Монгол хэлний хэлзүй ба үгсийн сан утгазүйн асуудал

5. Монгол хэлний нутгийн аялгуу судлалын ирээдүй ба судалгааны аргазүйн асуудал
6. Монгол хэлний баримт хэрэглэгдэхүүн дээр үндсэлсэн корпус судалгаа, хэл болон нутгийн аялгууны корпус
7. Монгол хэлний гарал ба газар нутгийн онцлогийг түүхэн харьцуулсан болон хэвшинжийн талаас судлах нь
8. Олон соёл хооронд монгол хэлний гүйцэтгэх үүрэг
9. Монгол хэлний универсал ба үндэсний шинж чанар дэлхийн хэлэнд эзлэх байр суурь
10. Varia (эрдэм шинжилгээний хурлын сэдвийн хүрээнд нийцэх бусад судалгааны чиглэлийн ажлыг хүлээж авна).

Эрдэм шинжилгээний хурлын хэл: орос, монгол, англи.

Эрдэм шинжилгээний хуралд оролцогчид бүртгэлийн хуудас бөглөж (Хавсралт 1), 2020 оны 2 дугаар сарын 1 өдрөөс өмнө дараах хаягаар илгээх шаардлагтай. E-mail хаяг: vostochnyi_fca@mail.ru

Захиалгын файлын нэр—оролцогчийн нэр (Иванов_захиалга). Оролцогчийн захиалга баталгаажсан болон эрдэм шинжилгээний хурлын хөтөлбөрт илтгэлийг багтаасан тухай **2020 оны 3 дугаар сарын 1 өдрөөс** хэтрэлгүй дуулгах болно. Эрдэм шинжилгээний хурлын дараа илтгэлүүдийг эмхэтгэн хэвлэхээр төлөвлөж буй болно. Илтгэлийн хэмжээ, хуудсын тоо, зохион байгуулах хороонд хэзээ илгээх зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг хурлын зар №2-т илгээх болно.

Томилолттой холбоотой гарах зочид буудал, хоол унд, хурал болох газар ирэх очих тээврийн зардлыг оролцогч тал өөрөө хариуцна.

Зохион байгуулах хорооны хаяг: Буриад Улс, Улаан-Үүд хот, Ранжуровагийн гуд., 4, өрөө 8408 (Бальжинимаева Баярма Дашидондоковна, БИС-ийн Дорно Дахины Хүрээлэнгийн Төв Ази судлалын тэнхмийн эрхлэгч), Утас: +7 (983) 338-59-29.

Хурлын зохицуулагч: Бадмацыренова Надежда Бадмажаповна, БИС-ийн Дорно Дахины Хүрээлэнгийн Төв Ази судлалын тэнхмийн доцент. Утас: +7 (9021) 61-38-89, Тонтоева Туяна Васильевна, БИС-ийн Дорно Дахины Хүрээлэнгийн Төв Ази судлалын тэнхмийн багш. Утас: +7 (914) 057-51-34.

Хуралд оролцогчийн бүртгэлийн хуудас

IV дахь удаагийн монгол хэл, хэлшинжлэлийн олон улсын эрдэм шинжилгээний хурал
«XXI зууны монгол хэл: Орчин үеийн хандлага ба судалгаа шинжилгээний хэтийн төлөв»*

Оролцогчийн овог нэр (бүтэн)	
Ямар ажил эрхэлдэг (байгууллагынхаа хаягаар)	
Албан тушаал (хөдөлмөрийн гэрээний дагуу)	
Эрдмийн цол зэрэг (байгаа бол)	
Илтгэлийн нэр	
Илтгэлийн товчлол (150 үгээс багагүй)	
Түлхүүр үг	
Цахим хаяг	
Ажил/гар утасны дугаар	
Шуудангийн хаяг (индекс бичнэ)	
Илтгэл тавихад шаардагдах техник хэрэгсэл	
Зочид буудал захиалга (тийм/үгүй)	

* Хуралд оролцогч болон хамтран илтгэгч бүр бөглөнө.

Эрхэм хүндэт нөхөд өө!

Зохион байгуулагч тал тус хурлын зарыг оролцох сонирхол бүхий бусад их дээд сургуулийн багш, эрдэм шинжилгээний байгууллагуудын ажилтан нарт дамжуулбал гүнээ талархах болно.